

## **ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ 10 САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 10 дүгээр сарын 10

Мандалговь хот

### **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Засгийн Газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар зэрэг шийдвэрийн заалтуудыг хяналтад авахуулан эзэнжүүлж, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийж үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан, мэдээлэл ирүүлсэн үйл явц, үр дүнг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

### **ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

2024 оны 10 сарын байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /unelgee.gov.mn/-д байршуулсан 93 шийдвэр: Засгийн газрын тогтоол-50, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-41, Засгийн газрын албан даалгавар-2 нийт 138 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 89.55 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хэрэгжилтийн үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 96 заалт нь нийт заалтын 72 хувийг
- Хэрэгжих шатанд 30 заалт нь 22 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 7 заалт 5 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон аймагт хамааралгүй заалтууд 5 заалт 0,37 хувийг эзэлж байна.

Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн явцыг Dundgovi.gov.mn сайт, төрийн байгууллагын цахим программ болох egr.e-mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулан ажиллаж хэвшил болоод байна.

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтдаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авч байна.

## ГУРАВ. ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд 10 сарын байдлаар хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 89,55 хувьтай байна. Мөн удаашралтай хэрэгжиж байгаа 7 заалтын хэрэгжилтийг авч үзвэл Урт хугацааны туршид хэрэгжих-6, Зохион байгуулалтаас шалтгаалсан 1 заалт байна. Удаашралтай хэрэгжиж байгаа заалтуудын бодит үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр сар бүр Төрийн захиргааны удирдлагын хэлтэст зөвлөмжийг хүргүүлэн эрчимжүүлэх чиглэл өгсөн нь хэрэгжилтийг чанартай тайлагнахад ахиц дэвшил гарч байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлагууд хяналтадаа авч, шийдвэрийн хэрэгжилтийн явцыг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах үүднээс Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг хяналтад бүрэн авах, тайлагнахад анхаарах зарим асуудлын талаарх зөвлөмжийг сар бүр өгч ажилласнаар тодорхой үр дүн гарч байна. Өнгөрсөн сартай харьцуулахад хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 11 заалт байснаас 6 заалт болон буурсан бөгөөд сар тодорхой ажлуудыг хийж хэвшээд байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд Засгийн газрын албан даалгаврын 2 заалтын хэрэгжилтийн явц хамгийн бага буюу 50 хувийн үзүүлэлттэй байна. Иймээс Засгийн газрын албан даалгаврын 2 заалтын хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд холбогдох хэлтсүүд эрчимжүүлэн анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хяналтад байгаа Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын холбогдох заалтуудаас бүрэн хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон нэг удаагийн шинжтэй 26 заалтыг түүвэрлэн хяналтаас хасуулах тэмдэглэгээг нэг бүрчлэн цахим системд орууллаа. /Хяналтаас хасуулах саналын дагуу [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим программаас хасч өгнө үү/

### ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Бодлого хариуцсан хэлтсүүдийн мэргэжилтнүүдэд:

- 1.Шинээр гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах.
- 2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа нотлох баримттай тайлагнаж хэвших шаардлагатай байна.

**ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**